

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/32/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ДАЛАНЗАДГАД СУМЫН 8 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.НАСАНБАЯР ТАНАА

2022.02.24 № 81

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Он дамжсан авлага үүсгэсэн, тооцоо нийлсэн акт үйлдээгүй, халдвар хамгааллын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, сүү цагаан идээ худалдан авах гэрээгээ зөрчиж эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх нь тодорхойгүй их хэмжээний аарцыг өөр газраас бэлтгэж зориулалтын бус газар хадгалсан, бараа материалын хяналтын тооллогоор хүнсний материал дутагдсан, нүүрсний худалдан авалт, хэрэглээнд хяналт тавьдаггүй, норм хэтрүүлэн зарцуулсан, бараа материалын агуулах бүртгэл, хүлээн авалтын баримт үйлдээгүй, анхан шатны бүртгэлийг тухай бүр үнэн зөв хөтлөөгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар", УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 Бараа материал, санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

010300147


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	49.30	76.50
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,332.20	1,293.40
	Нийт хөрөнгийн дүн	1,381.50	1,369.90
	Нийт өр төлбөрийн дүн	1.40	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,380.10	1,369.90
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,381.50	1,369.90
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	495.50	465.90
	Үйл ажиллагааны зардлын дүн	540.50	474.50
	Үйл ажиллагааны үр дүн	- 45.00	- 8.60
	Үйл ажиллагааны бус үр дүн		- 1.60
	Үйл ажиллагааны нийт үр дүн	- 45.00	- 10.20
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,380.10	1,380.10
	Тайлант оны үр дүн		- 10.20
	Эцсийн үлдэгдэл	1,380.10	1,369.90
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	495.50	434.10
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	495.50	434.10
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	423.80	406.80
	Урсгал зардал	423.80	406.80
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	423.80	406.80
	Улсын төсвөөс санхүүжих	391.60	381.70
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32.20	25.10
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих		-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхэд бүрийг хамгаалах, хөгжүүлэх, сурах үйлийг дэмжих, тэдний суурь хэрэгцээг хангахад тулгарч буй бэрхшээлийг арилгах сургалтын арга зүйд шинэ дэвшил гаргаж, орон нутгийн бодлого шийдвэрт уялдуулан хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллах зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2021 оны 02 сарын 16-ны өдрийн Д38Ц2021/01 дугаартай гэрээгээр "Давхар сар" ХХК-аас 7,200,000 төгрөгийн төсөвт өртөгтэй сүү, сүүн бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулсан боловч 2021 оны 12 сарын 15-нд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын иргэн А.Хандбаяраас 500кг аарцыг 4,000,000 төгрөгөөр худалдан авсан байна. Уг аарц нь зориулалтын бус савлагаатай, айлын гаржид хадгалагдаж байгаа нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 /цэцэрлэгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах/, 11.2.11 /сургалтын орчин, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын стандарт, норм, норматив, багшийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах/-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангахаар агуулахын бүртгэлийг материалын нэр төрлөөр эд хариуцагч хөтлөөгүй, нүүрс хүлээн авахдаа жижиглэнгээр фортор машинаар рэсс хийн буулгадаг бөгөөд худалдан авсан хэмжээгээр нүүрсээ хүлээн авсан эсэх нь тодорхойлогдохгүй, бараа материал хүлээн авалтын баримтыг зохих ёсоор үйлдээгүй байгаа нь залилан үүсэх эрсдэлийг бүрдүүлсэн ба нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг оруулаагүй, тухайн жилийн батлагдсан төсөв, аудитын дүгнэлт, тайлан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21.0 сая төгрөгийн 14 гүйлгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 155.8 сая төгрөгийн дүн бүхий 5 ажил гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулах тухай 20.5 сая төгрөгийн 1 шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, 6.1.6, 6.4.4, 6.4.5-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хүүхдийн хоолны цэсийг хүнсний зарлагын тайлантай тулган баталгаажуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг анхан шатны баримтаас хөөн шалгах нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 306.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40.1 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 264.2 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 0.4 сая төгрөгийн зөрчилд дотоод хяналтыг сайжруулах 1 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	8	108.8	4	40.1	1	1.4	2	66.9	1	0.4
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	1	197.3					1	197.3		
3	Нийт дүн	9	306.1	4	40.1	1	1.4	3	264.2	1	0.4